



## МОНГОЛ, ЯПОН УЛСЫН БАГА ДУНД, СУУРЬ БОЛОВСРОЛЫН ХӨГЖМИЙН СУРГАЛТЫН АГУУЛГЫГ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Чойдогжамц Отгонбаяр<sup>а</sup>, Гриш, Заяабат<sup>б</sup>, Hisako Watanabe<sup>в</sup>  
МУБИС-Багшийн сургууль

Холбоо барих зохиогч: otgonbayar.ch@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

### Удиртгал

Бидний энэхүү судалгаа нь Монгол, Япон хоёр улсын бага дунд, суурь боловсролын урлагийн сургалтын хөтөлбөрийн бүтэц, сургалтын зорилго, агуулгыг харьцуулан судлах зорилготой юм. Хөгжмийн хичээл бүр нь шинжлэх ухааны үндэслэлтэй, өргөн дэлгэр утга агуулгатай, тодорхой нэгэн чиглэлтэй, бусад хичээлүүдтэй уялдаа холбоотой, шинэ сэргэг материалаар баяжигдсан, хүүхдийн нас, оюун ухаан, бие бялдрын онцлог хэрэгцээ шаардлагыг хангасан байх ёстой гэж “Урлаг” хөтөлбөрт тусгасан байна (<https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/Curriculum/EBS/Suuri.pdf>).

Мөн Бага, дунд боловсролын хуулийн 2.1 зорилго нь суралцагчид ерөнхий боловсрол эзэмшүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах, авьяас чадвараа хөгжүүлэх, амьдрал, хөдөлмөрт болон тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд нь туслахад оршино хэмээн заажээ (<https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/Curriculum/EBS/Baga.pdf>, 2019.х.66).

Ийнхүү бага дунд боловсролын хууль, бага дунд, суурь боловсролын урлагийн хөтөлбөр, сурах бичигт үндэслэн Монгол, Япон хоёр улсын хөгжмийн сургалтын агуулгыг харьцуулан уг судалгааг хийх болсон.

### Онолын арга зүй

“Хүн болох” үндэс суурь бага насанд тавигддаг. Хүүхэд бүр хүмүүний зан чанар, харилцааны үнэт зүйлсийг багаасаа эзэмшиж, төлөвших нь тэдний насан туршийн ажил, амьдралд шийдвэрлэх үүрэгтэй. Хүний хөгжил, төлөвшлийн судалгаагаар нийгэмшихүйн чадамж (EQ) нь оюуны чадамж (IQ)-ийн суурь шийдэл буюу хүний амжилтын үндэс болохыг судлаачид үзэж байна (Батсүх, 2011, х.79). Хүүхдийг гоо сайхны ертөнцтэй танилцуулж гоё сайхныг мэдүүлэхэд сургуулийн нас хамгийн зохистой үе байдаг (Ветлугина Н.А, 1976 стр 98). Сургуулийн насны хүүхдийг хөгжмийн урлагаар хөгжүүлэхэд дуу чухал үүрэгтэй. Энэ насны хүүхдийг урлагаар


хөгжүүлж төлөвшүүлэхэд чиглэсэн К.Орф, З.Кодай, Е. И. Алмазов, Н. А. Метлов, Н. А. Ветлугина, А. Д. Войнова нарын хөгжмийн сургалтын онол арга зүйг дэлхий нийтэд түгээмэл хэрэглэж байна.

Монгол болон Япон улсын бага, дунд, суурь боловсролын урлагийн сургалтын хөтөлбөрийн бүтэц, зорилго, агуулгын ялгаатай ба төсөөтэй талыг баримт бичигт дүн шинжилгээ хийх аргаар, харьцуулсан судалгаа хийсэн юм. Судалгаанд Монгол улсын суурь боловсролын сургалтын хөтөлбөр 2019 оны “Урлаг”-ийн сургалтын хөтөлбөр, Япон улсын Ёкохама хотын бага дунд боловсролын сургалтын хөтөлбөр 2018 “Дуу хөгжмийн хичээл”-ийн хөтөлбөрийн бүтцийг харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.

Хүснэгт 1. Суурь боловсролын хөтөлбөрийн жишиг

Чадвар	6-7-р анги
Мэдрэх, ойлгох	Урлагийн бүтээлийн сайхныг мэдэрч, ойлгох, тэдгээрийн талаар эргэцүүлж, асуулт асуух - Бүтээлийн санаа, үүрэг зорилгыг тодорхойлох - Бүтээлийн дүр, дүрслэлийн талаар таамаглах, асуулт асуух, асуултад хариулах, дүрслэн бодох
Сонирхон судлах	- Шинэ бүтээлийн санаа олохын тулд хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийн талаар мэдээлэл цуглуулах, ангилах, уншиж судлах - Санаагаа илэрхийлэх арга замыг багштайгаа хамтран төлөвлөх, хэрэглэгдэхүүнээ сонгох - Олсон санаагаа бодитойгоор зохиомжлон дүрслэх, найруулах - Бүтээлийн арга, хэрэглэгдэхүүнийг харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх
Бүтээх, хөгжүүлэх	- Уран бүтээлийн дүр, дүрслэл, агуулгыг мэдэрч гүйцэтгэх, гүйцэтгэлийн талаар санаа бодлоо хуваалцах; - Гүйцэтгэлийн чадвартаа тулгуурлан төрөл бүрийн хэрэглэгдэхүүн ашиглан жижиг хэлбэрийн бүтээл хийх, зохион найруулах; - Бүтээлийн санаагаа сайжруулах, хувилбар боловсруулах;
Илэрхийлэх, үнэлэх	- Бүтээлийн санаа, арга барил, хэрэглэгдэхүүний талаар илтгэх, туршлагаа хуваалцах, үнэлэх - Хамтарч хийсэн бүтээлийн агуулга, дүр, хэрэглэгдэхүүний талаар бусдад танилцуулах, үнэлэх

Дээрх хүснэгтээс харахад Монгол улсын суурь боловсролын урлагийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид бүтээлч эрэлхийллийн арга барилд суралцаж, мэдрэх, ойлгох, сонирхон судлах, бүтээх, хөгжүүлэх, илэрхийлэх, үнэлэх гэсэн чадваруудыг эзэмшихээр тусгасан байна. Монгол улсын суурь боловсролын “Урлаг”-ийн сургалтын хөтөлбөр нь зорилго, зорилт, арга зүй, зохион байгуулалт, орчин, үнэлгээ гэсэн бүтэцтэй байна.



Япон улсын хөгжмийн сургалтын хөтөлбөр нь зорилго, дуулах, хөгжимдөх, дуу бүтээх, сонсох, нийтлэг зүйлс гэсэн бүтэцтэй байна. 2018 оны сургалтын заах аргагүйн агуулгын сайжруулалтаар хүмүүжлийг зорьж буй чанар, чадварууд тус бүрээр цэгцэлж боловсруулсан байна. Тухайлбал:

1/ “Мэдлэг болон чадвар”-ыг эзэмших

2/ “Сэтгэхүйн чадвар, дүгнэх чадвар, илэрхийлэх чадвар”-г сургах

3/ “сурахад чиглэсэн чадвар, хүн чанар зэрэг”-ийг хөгжүүлэхэд дэм болох зүйлийг зорилго болгож, эдгээрийг хөгжүүлэхийн тулд “хөгжимлөг үзэл, бодол”-ыг хөдөлгөх шаардлага байгааг тусгасан байна (цахим, 2018-2020)

Япон улс нь 2018 онд Ёкохама хотын сургуулийн хөтөлбөрт дуу хөгжмийн хичээлийн хувьд, төлөвшил хүмүүжил (дуу хөгжмөөр дамжуулах олж авах) чанар, чадвар нь “амьдрал болоод нийгмийн дуу хоолой, дуу хөгжмийн соёлтой гүн холбогдсон чанар, чадвар” бөгөөд эдгээр нь дуу хөгжмийн үйл ажиллагааг хөгжилтэйгээр мэдрэх байдлаар дуу хөгжимд дурлах сэтгэлтэй нь хамтад нь төлөвшүүлж байдаг. Дуу хөгжимд хандах мэдрэмжийг баяжуулж, дуу хөгжимтэй ойртуулж, мэдрэмж илэрхийллийг баяжуулах хичээл гэж тусгажээ.

Монгол улсын суурь боловсролын “Урлаг” сургалтын хөтөлбөрийн агуулгад дараах мэдлэг чадварыг эзэмшинэ гэж тусгажээ (нар, 2019). Үүнд:

## 6.1. УРЛАГИЙН ТӨРЛҮҮД

6.1а. Урлагийн бүтээлийн агуулга, дүр, үүрэг зорилго, илэрхийллийн арга барилыг сонсож тодорхойлох, тайлбарлах

6.1б. Дүрслэх урлаг, уран зохиолын төрлөөр туурвисан бүтээлийг хөгжмийн хэлний хэрэглүүрээр (хөг эгшиглэгээ, аялгууны шинж төрх, өнгө аяс, айзам хэмнэл, хурд, хүч, зэмсэгжилт г.м) дүрслэн илэрхийлэх, таамаглах

6.1в. Урлагийн төрлүүдэд ижил сэдвээр туурвигдсан бүтээлийг харьцуулан жишээгээр тайлбарлах

6.1г. Хөгжмийн зохиол, урлагийн бусад төрлөөр туурвигдсан бүтээл хоорондын уялдаа холбоо, ялгааг илрүүлэх

6.1д. Өөрийн сонирхсон урлагийн төрлөөр онцлох бүтээлийг сонгон жишээгээр тайлбарлах

6.1е. Урлагийн төрлүүдийн харилцан нөлөөллийг (дүрслэх урлаг-хөгжим, уран зохиол-хөгжим, бүжиг-хөгжим, кино-хөгжим, театр-хөгжим) тайлбарлаж жишээгээр харуулах

## 6.2. ХӨГЖМИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ

6.2а. Дуу, романс, кантат, оратори, реквием, дуурь зэрэг дуулаачийн төрлүүдийг сонсож, тэдгээрийн онцлог ялгаа, бүтэц хэлбэр, илэрхийллийн аргыг тодорхойлох

6.2б. Аяз, этюд, прелюди, серенада, сонат, концерт зэрэг дан хөгжмийн зохиолын төрлүүдийг сонсож, тэдгээрийн онцлог ялгаа, бүтэц хэлбэр, илэрхийллийн арга хэлбэрүүдийг тодорхойлох

6.2в. Хөгжмийн зохиолыг сонсоод давталт, ялгарамж, зэмсэгжилтийг тодорхойлох

6.2г. Хөгжмөө сонсоод зохиолын гол сэдэв аялгууны ноотонд задлал хийж, цараа, хурд, хүчний өөрчлөлт, аялгууны хөдөлгөөн, шинж төрх, айзам хэмжээ, хэмнэлийн

зураглал, эгшиглэгээний онцлогоор агуулга дүрийг таамаглах, жишээгээр тайлбарлах

6.2.д. Гоцлол, цөөхүүл, найрал хэлбэрээр дуулахдаа хоолой тус бүрийн үүргийг ялган таних, тайлбарлах, ая, шүлэг, мэдрэмжид тулгуурлан утга санааг илэрхийлэх  
6.2.е. Бишгүүрээр болон өөрийн сонирхсон хөгжмийн зэмсгээр хөгжимдөх арга барил эзэмшсэнээ гоцлол, цөөхүүл, найрал хэлбэрээр гүйцэтгэх, зэмсгийнхээ үүрэг, онцлогийг тодорхойлж, илэрхийлэх аргаа боловсруулах (<https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/Curriculum/EBS/Suuri.pdf> 2015.х.107). Монгол улсын дунд боловсролын “Урлаг” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид уран бүтээлийг эрэлхийллийн арга барилд суралцах, шинэ бүтээлийн талаар мэдээлэл цуглуулах, ангилах, унших, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, урлагийн бүтээлийн дүр, дүрслэл, агуулгыг мэдэрч гүйцэтгэх, илтгэх, туршлагаа хуваалцах, үнэлэх, танилцуулах чадвартай болно гэж тусгасан байна.

### Хүснэгт 3. Япон улсын хөгжмийн хичээлийн агуулга /6-р анги/

☆ Дуу хөгжмөөр бодлоо дамжуульа

(Сэтгэлээр холбогдох дуу хоолой)

“つばさをください” /Далавчтай болгож өгөөч/

- 1, Дуу хоолойгоор дамжуулан сэтгэлээрээ холбогдох  
(Илэрхийлэл, найрал дуу, аялгуу)
  - Аяыг мэдэрч, шүлгийн агуулгыг мэдэрч дуулах.
  - Хөгжмөө сонсонгоо өөрчлөлтийг мэдэрч дуулах.
    - ・ 明日という大空 Маргаашийн тэнгэр
    - ・ おぼろ月夜. Бүрхэг сартай шөнө
    - ・ 星空はいつも. Ододтой тэнгэр үргэлж

Өнгө, хурд, аялгуу, хүчдэл, хэсэг,  
дууны давхцал, уриалах болон хариулах

Хурдны тэмдэглэгээ ♪ = 120

Дуулах өнгө (Дуулах арга)

- 2, Янз бүрийн өнгийг мэдэрч сонсох  
(Үзүүлбэр, илэрхийлэл, хөгжмийн аялгуу · хөгжим зохиох)
  - Олон өнгийн дуугаралтыг мэдэрч, түүнийг улам сайжруулан илэрхийллээ баяжуулан сонсох
    - ・ 木星(ホルスト) Холст
    - ・ ラバースコンチェルト Рабасконцерт
    - ・ ボイスアンサンブル Войсансембл

Дууны өнгө, аялгуу, давталт, хувиргалт, ритм

Дууны давхцал, босоо ба хэвтээгийн холбоо

- 3, Аялгууны онцлогийг тод илэрхийлэх  
(Илэрхийлэл, найрал дуу, хөгжмийн ая)
  - Аялгууны дээшилж, доошилж буйг бүхэлд нь мэдэрч дуулж хөгжимдөх
    - ・ われは海の子 Бид бол далайн хүү
    - ・ メヌエット Менют

Ритм, аялгуу, хүчдэл, өнгө,  
дууны давхцал, хэсэг

- 4, Янз бүрийн аккордын дуугаралтыг мэдрэх  
(Илэрхийлэл, найрал дуу, хөгжмийн аялгуу · хөгжим зохиох)
- Аккордын дуугаралтын сонголонтой шилжилтийг мэдэрч, илэрхийллээ баяжуулах
    - 星の世界 Дэлхий гариг (ижил хоолой, 3 хоолой нийлсэн найрал дуу)
    - 雨の歌 Борооны дуу
      - 和音の音で旋律づくり Аккордоор ая зохиох
- Аялгуу, дууны давхцал, аккордны дуугаралт  
Дэвсгэр хөг, босоо болон хэвтээгийн харилцаа, ритм  
Дуулах арга (хоолой өөрчлөгдөх үе)  
Ля минорын ( I、IV、V、V 7)
- 5, Аялгууны өөрчлөлтийг мэдэрч ойлгох  
(Илэрхийлэл Дуулах Хөгжимдөх Сонсох)
- Аялгууны өөрчлөлтийг мэдэрч, хөгжимдөх, сонсох
    - Бодлын аялгуу (Найрал дуу, ямар мэдрэмж төрсөн вэ, яагаад? Яаж мэдэрсэн вэ?)
    - Унгар бүжиг (Брамс)
    - Салхи сөрөн (Хөгжимдөх, дуулах)
- Ритм, аялгуу, хүчдэл, дууны давхцал, хурд  
Дэвсгэр хөг, давталт, өөрчлөлт, өнгө  
(мажор болон минор)
- 6, Шүлэг, дууны холбоог мэдрэх  
(Илэрхийлэл Дуулах Сонсох)
- Япон дууг сонсож дуулж, үг болон аялгууг холбож мэдрэх
    - 花 Цэцэг
    - 箱根八里 Хагонэ Хачири
    - 荒城の月 Коожоно цуки
    - ふるさと Төрсөн нутаг
- Хурд, аялгуу, хүчдэл, дууны давхцал,  
Өнгө, өөрчлөлт  
(Найрал дуу болон дууны төрөл, дуу хүн хоорондыг холбодог.)
- 7, Япон болон дэлхийн дуу хөгжмийг мэдрэх  
(Илэрхийлэл Дуулах Сонсох)
- Япон болон дэлхийн дууны онцлогийг мэдэрч дуулах, сонсох
    - 越天楽今様 (Дуулах)
    - 雅楽「越天楽」 Япон хуучны дуу (сонсох)
    - Дэлхийн улс орны дуу хөгжим  
(Англи, Сенегал, Турк, Монгол, Өмнөд Америк, Индонез)
- Өнгө, аялгуу, дууны давхцал, хэмжээ  
(өөрийн таблет ашиглан интернэтээр судлах)
- 8, Дуу хөгжмөөр дамжуулан бодлоо дамжуулах  
(Илэрхийлэл, Дуулах)
- Өдийг хүртэлх сурсан зүйлээ сайжруулаад, өөрийн бодлоо дамжуулахаар дуулах
    - きっと届ける (Найрал дуу)
    - さようなら友よ (Найрал дуу)
    - あおげばとおとし (Найрал дуу)
- Аялгуу, дууны давхцал, хэсэг, хүчдэл  
(Төгсөлт дээр дүүлэх)

## Судалгааны үр дүн

Харьцуулсан судалгааны гол санаа дараах үзүүлэлтүүдийг сонгон авч хэрэглэсэн. Үүнд: 6-р ангийн урлаг хичээлийн зорилго, агуулгыг хамруулж харьцуулсан авч үзсэн болно. Харьцуулалтын ялгаатай ба төсөөтэй талуудаар нь дараах хүснэгтэд нэгтгэн үр дүнг харууллаа.

### Хүснэгт 4. Урлаг хөтөлбөрийн зорилгын харьцуулалт

Бага дунд, суурь боловсролын урлагийн хөтөлбөрийн зорилго

Монгол улс	Япон улс	Монгол улс	Япон улс
Сурагч нь хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг танин мэдэх арга барилтай, гоо сайхны мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх, хөгжүүлэх, соёлын өв, уламжлалаа хүндэтгэх хүсэл эрмэлзэлтэй иргэн болж төлөвшинө. 1.2. Зорилт 1.2.1. Урлагийн хэл, нэр томьёог танин мэдэх; 1.2.2. Хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийг тайлбарлах, илэрхийлэх; 1.2.3. Урлагийн бүтээл, үндэсний өв уламжлалаа хүндэтгэх хүсэл эрмэлзэлтэй болох.	Илэрхийлэл болон үзүүлбэр бүхий ажиллагаагаар дамжуулан дуу хөгжмийг үзэх үзэл/бодлыг суулгаж, амьдрал нийгмийн өнгө, дуу хоолойтой хангалттай холбогдох авьяас, чадварыг хөгжүүлэхийг зорьдог.  (1) Аялгууны мэдрэмж, бүтэц зэрэгтэй холбогддог талаар ойлгож, үзүүлмээр байгаа дуу хөгжмийг илэрхийлэхийн тулд хэрэгцээт чадварыг эзэмшүүлэх.  (2) Дуу хөгжмийн илэрхийллийг олон янзаар хувиргах, дуу хөгжмийг мэдрэх чадвартай болгох.  (3) Дуу хөгжмийн сайхныг мэдэрснээр дуу хөгжмийг хайрлах сэтгэл, мэдрэмжийг хөгжүүлэхийн хамт дуу хөгжимтэй дотносох байдлыг төлөвшүүлж, баялаг оюун санааны боловсролыг суулгах.	Сурагч нь аливаа юмс, үзэгдэл, урлагийн бүтээлийг судлах бүтээлч эрэлхийллийн арга барилтай, өөрийн авьяас, гоо сайхны мэдрэмжээ илэрхийлж, хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй, урлаг соёлыг эрхэмлэдэг иргэн болж төлөвшинө. 1.2. Зорилт 1.2.1. Урлагийн бүтээлийг сонирхон судалснаар урлагийн хэл, нэр томьёог ойлгож хэрэглэх; 1.2.2. Урлагийн бүтээлийг мэдэрч ойлгох, сонирхон судлах, бүтээх хөгжүүлэх, илэрхийлэх, үнэлэх замаар бүтээлч эрэлхийллийн арга барилд суралцах; 1.2.3. Гүйцэтгэлийн ур чадвараа хөгжүүлэх явцдаа урлагийн сайхныг мэдэрч, гоо зүйн мэдрэмжээ хөгжүүлэх, илэрхийлэх; 1.2.4. Үндэсний болон хүн төрөлхтний урлагийн баялаг өв сан, үнэт зүйлсийг хүндэтгэн бахархаж, хамгаалдаг болно.	Илэрхийлэл болон сонсох үйлээр дамжуулан дуу хөгжмийг үзэх үзэл/бодлыг суулгаж, амьдрал нийгмийн өнгө, дуу хоолой болон дуу хөгжмийн соёлтой хангалттай холбогдох авьяас, чадварыг дараах байдлаар хөгжүүлэхийг зорьдог.  (1) Аялгууг мэдрэх, дуу хөгжмийн бүтэц болон суурь дэвсгэр өнгөтэй холбогдох, дуу хөгжмийн олон талтай холбогдохын учрыг ойлгохын хамт өөрийн санаа бодлыг хөгжүүлэн дуу хөгжмийг илэрхийлэхийн тулд хэрэгцээт чадварыг эзэмшүүлэх.  (2) Дуу хөгжмийг төрсөн сэтгэгдлээ өөрийнхөөрөө илэрхийлэх, дуу хөгжмийн сайн тал, гоо сайхны мэдрэмжтэйгээр сонсож чаддаг болгох.  (3) Дуу хөгжмийн сайхныг мэдэрснээр дуу хөгжмийг хайрлах сэтгэл, мэдрэмжийг хөгжүүлэхийн хамт дуу хөгжимд хандаж буй сэтгэгдлийг баяжуулж, гүн сэтгэл хөдлөлийн суурийг бий болгох.

Ялгаатай тал	Төсөөтэй тал	Ялгаатай тал	Төсөөтэй тал
<p>-Японд хэнийг бэлтгэх вэ? гэдэг зорилготой</p> <p>- Зөөлөн дулаан хүүхэд бэлтгэх ба зөөлөн ур чадвар</p> <p>- Монгол улс азид өрсөлдөхүйц хүүхэд бэлтгэх гээд байгаа ч юм шиг. Ийм хүнд сургалтын агуулгатай байгаа нь судалж байх хугацаанд харагдаж байна.Цаашид хөтөлбөр, сурах бичгийн агуулгыг уяг хатан болгох хэрэгцээ шаардлага байна.</p> <p>- Гадаад дотоодын зохиол бүтээл, урлагийн төрөл зүйл байдаггүй тусгаж өгөөгүй гэс өөр ялгаатай байна</p>	<p>- Хөгжмийн боловсролыг 9 жилээр олгох нь төсөөтэй байна.</p>	<p>- Япон улсын хөгжмийн боловсролын хөтөлбөрийн тухайд хүүхдийг амьдрал дээрх дуу хоолойтой олон талаар холбогдох авьяас, чадварыг хөгжүүлэхийг зорихоос гадна хүмүүжил төлөвшлийг суулгах авьяас, чадвар болох: Монгол улсын хөгжмийн хөтөлбөрийн тухайд урлагийн хэл, нэр, бүтээлийг танин мэдэх , гоо сайхны мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх, үндэсний өв уламжлалаа хүндэтгэх гэж тусгасан байна</p>	

Монгол улсын хөгжмийн хөтөлбөрийн тухайд урлагийн хэл, нэр, бүтээлийг танин мэдэх, гоо сайхны мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх, үндэсний өв уламжлалаа хүндэтгэх гэж үзжээ.

Япон улсын хөгжмийн боловсролын хөтөлбөрийн тухайд хүүхдийг амьдрал дээрх дуу хоолойтой олон талаар холбогдох авьяас, чадварыг хөгжүүлэхийг зорихоос гадна хүмүүжил төлөвшлийг суулгах авьяас, чадвар болох:

- (1) -д”мэдлэг болон чадвар”-ыг олж авах,
- (2) -д”сэтгэлгээний чадвар, дүгнэх чадвар, илэрхийлэх чадвар”-ыг хөгжүүлэх,
- (3) -д”суралцахад чиглэсэн чадвар, хүнлэг байдал зэрэг”-ийг бага багаар эзэмшүүлэхэд чиглэсэн бүрэлдэхүүн хэсэг болох,

Монгол, Япон хоёр улсын бага, суурь боловсролын 6-р ангийн хөгжмийн сургалтын агуулгыг харьцуулан авч үзэхэд,

## Хүснэгт 4. Хөгжмийн хичээлийн агуулга /6-р анги/

Монгол улс		Япон улс		
Урлагийн төрөл зүйлүүд	Хөгжмийн төрөл зүйлүүд	Дан хөгжмийн төрөл	Илэрхийлэх	Сонсох
Урлагийн төрлүүд Дүрслэх урлаг ба хөгжим Уран зохиол ба хөгжим Театр ба хөгжим Бүжиг ба хөгжим Кино ба хөгжим	Дулаачийн хөгжмийн төрөл: Дуу Романс Баллада Вокализ Опера Реквиен Кантат Оратори	Этюд_судалбар аяз Прелюди_эхлэл хөгжим Ноктюрн_ үдшийн хөгжим Серенада_ үдшийн хөгжим Симфони_яруу зохиол Рапсоди_тууль Сонат_зөрчилт хөгжим Сюит_чуулбар Концерт	Дуулах хөгжимдөх, дуу хөгжим бүтээх гэсэн 3 салбараас бүрдэнэ	Тусдаа 1 хэсэг болно.
Ялгаатай тал		Төсөөтэй тал	Ялгаатай тал	Төсөөтэй тал
-Монголд урлагийн төрөл зүйлээс сонсох, тайлбарлах, дүрслэн илэрхийлэх (хөг эгшиглэгээ, аялгууны шинж төрх, өнгө аяс, айзам хэмнэл, хурд, хүч, зэмсэгжилт) гм - Японд дуу хоолойгоор дамжуулан сэтгэлээрээ холбогдох (Илэрхийлэл, найрал дуу, аялгуу) - Аяыг мэдэрч, шүлгийн агуулгыг мэдэрч дуулах. - Хөгжимөө сонсонгоо өөрчлөлтийг мэдэрч дуулах. Япон улсад 1-3-р ангид дуугаа давтаж жижиг тойргоор хичээл нь явагддаг.			Японд хөгжмийн хичээлийг онолоос эхэлдэггүй. Эхлээд дуунаас эхэлдэг Монголд хөгжмийн онол эхэлдэг энэ тэс өөр ялгаатай байна.	-Хөгжим сонсох үйл ажиллагаа нь адил зүйл байна

Монгол улсын хөгжмийн сургалтын сурах бичгийн агуулганаас харахад янз бүрийн хөгжим, симфони тусгасан нь хэтэрхий их өргөн агуулга тусгасан байгааг харуулж байна.

Харьцуулсан судалгааны дээрх үзүүлэлтээр гарсан үр дүн Монгол Япон улсын бага, дунд сургуулийн “Урлаг” хөтөлбөр, хөгжмийн сурах бичгийн агуулга хүндэвтэр ба Япон улсын хөгжмийн сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулга зөөлөн ур чадварруу хандсан гэж үзэж байна.

### Дүгнэлт

Монгол улсын урлагийн сургалтын хөтөлбөрийн бүтэц, зорилго, агуулгыг 6-р ангийн сурах бичигт үндэслэн Япон улсын бага дунд хөгжмийн сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулгад харьцуулсан судалгаа хийсэн. Харьцуулсан судалгаанаас харахад манай улсын суурь боловсролын урлаг сургалтын хөтөлбөрийн агуулга Монгол хүүхдийг дэлхийд өрсөлдөхүйц болгон урлагийн төрөл бүрээр бэлтгэж байгаа байдал ажиглагдлаа. Иймд дараах дүгнэлтийг өгч болох юм.

Монгол улс нь урлагийн цогц хөгжил, зан чанар, хүн болох төлөвшилд илүү анхаарсан мөн бусад улс орны онцлогийг тусгасан, хүүхэд өөрөө идэвхтэй, чадвартай суралцагч гэсэн конструктив онолд тулгуурласан, урлагийн бүрэлдэхүүн бүрээр гол зорилтуудыг тусган томьёолжээ гэж үзэж байна. Монгол улс хүүхдийн бие даасан байдлыг чухалчилдаг бол Япон улс нь бие хүн болж төлөвших, амьдрах ухааны боловсролд илүү анхаардаг байна.

Япон улсын хөгжмийн хичээлийн агуулгад илэрхийлэх боловсрол ба “Хөгжмөөр дамжуулан баяр баясгаланг мэдэрч, хөгжимд дурлахын хамт мэдрэмжийг нь хөгжүүлэх, хөгжимтэй илүү ойртох хандлагыг бий болгодог хичээл юм” гэж соёл шинжлэх ухааны яам заасны дагуу, маш хөгжилтэй гэсэн бодлыг 1-рт тавьж, түүнд тохирсон сурах бичиг, гарын авлага, бусад хэрэглэгдэхүүнийг сонгох ба түүнтэй нийцүүлсэн заах аргагүй хамгийн чухал гэж үзсэн байна.

Цаашид “Урлаг” сургалтын хөтөлбөрийн агуулгыг эргэн харж хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон уян хатан, зөөлөн ур чадвар эзэмшүүлэх саналыг дэвшүүлж байна.

## **Ном зүй**

А.Баримт бичиг

<https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/Curriculum/EBS/Baga.pdf>-(2019).

БСШУСЯ. (2019). *Бага дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар.*

Улаанбаатар: Адмон. цахим, Б. я. (2018-2020). 2020 оноос хэрэгжсэн). Япон.

## A COMPARISON STUDY OF THE CONTENT OF PRIMARY AND PRIMARY EDUCATION MUSIC IN MONGOLIA AND JAPAN

Otgonbayar.Ch<sup>a</sup>, Zayabat.G<sup>б</sup>, Hisako Watanabe<sup>в</sup> Ph.D., Master  
<sup>a</sup>Teachers school, MNUE;

Corresponding author: otgonbayar.ch@msue.edu.mn 

### **Abstract**

Developing children through art has many benefits.

Music, in particular, develops children's mindsets, emotions and feelings comprehensively. It also supports and improves children's language skills, mathematical thinking skills and brain development.

In our country, the general education curriculums include teaching music classes from elementary to high school levels.

We are conducting comparative studies between the music education curriculums at Mongolian and Japanese secondary schools. In this study, we aimed to review the music curriculums for the sixth grade at Mongolian and Japanese secondary schools. The study observed that both Mongolia and Japan pay great attention to students' art education, especially music education.

### **Keywords**

Music Education, Lessons, Content, Purpose, Listening and Expressing Music